

“ДОРНОД МОНГОЛ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД 2008 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АРХЕОЛОГИЙН ХЭЭРИЙН СУДАЛГАА

Д.НАВААН¹, М.ЭРДЭНЭ², Д.ХАТАНБААТАР³, Д.ТҮМЭН⁴

^{1, 2, 4}МУИС, НШУС, Археологи-Антропологиин тэнхим

³ШУТИС, НТС, Түүх-Аялал жуулчлалын профессорын баг

Түлхүүр үгс: Азийн судалгааны төв, Улаан Зуух, Замын Хашаат, хүрлийн үеийн дурсгал, түрүүлэг нь харуулж оршуулах зан үйл, монгол бичгийн дурсгал

ТОВЧ АГУУЛГА: МУИС-ийн Археологи-Антропологиин тэнхим 2008 онд Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт хээрийн судалгаа явуулж Устай бургастай, Ачаат уул, Яхь нуур зэрэг чулуун зэвсгийн бууц, Цагаан чулуутын бүлэг оршуулга болон урьд өмнө судлагдаагүй Улаан зуухын бүлэг булш, Сүмийн довжоо хэмээх эртний хотын турь, монгол бичгийн дурсгал зэргийг шинээр илрүүлэн судалж урьдчилсан үр дүнг нийтэлж байна. Хайгуул болон малтлага судалгааны явцад шинээр илрүүлсэн оршуулгын бүлэг дурсгалуудыг бүртгэн авч дэвсгэр зургийг хавсаргав.

МУИС-ийн Археологи-Антропологиин тэнхим 2003 оноос МУИС-ийн Азийн судалгааны төвийн санхүүжилтээр “Дорнод Монгол” судалгааны төсөл боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд жил болгон Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт хээрийн судалгаа явуулж байна. 2004 онд Сүхбаатар аймгийн Онгон сумын нутаг Таван толгойд бүлэг булш нээн илрүүлж малтан судлахад XIII зууны үеийн язгууртны дурсгал болох нь тогтоогдсон бөгөөд 2007 он хүртэл археологийн малтлага хийн энэ дурсгалыг судалгааны хүрээнд оруулсаар ирсэн билээ.

Онгон Таван толгойн дурсгал XIII зууны үеийн археологийн судалгаанд чухал ач холбогдолтой болсныг харгалзан хайгуул шинжилгээний ажлыг түүний зах зэргэлдээ газруудад, улмаар Дорнод Монголын өргөн цар хүрээтэй нутаг дэвсгэрт үргэлжлүүлэн явуулах эрдэм шинжилгээний ажлын зайлшгүй шаардлага урган гарсан юм.

2008 оны хээрийн судалгааны ангийн үйл ажиллагаа нь Дорнод Монголын нутагт урьд өмнө тэмдэглэгдээгүй байсан археологийн дурсгалыг хайн илрүүлэх, шинээр олдсон дурсгалын газар зүйн байршлыг тэмдэглэн бүртгэж авах, судлах, хайгуул хийсэн нутаг дэвсгэр дэх урьд өмнө судлагдаагүй байсан дурсгал, объектыг судалгааны хүрээнд оруулан малтан шинжлэх, монголын эртний түүхийн судалгааг шинэ хэрэглэгдэхүүн, олдвороор баяжуулахад чиглэгдсэн болно.

Уг хээрийн судалгааны явцад хуучин чулуун зэвсгийн 1, шинэ чулуун зэвсгийн үед холбогдох 2 суурин газарт хайгуул судалгаа явуулж, урьд өмнө төдийлөн малтан судлагдаагүй байсан хүрэл зэвсгийн үед холбогдох 2 бүлэг булшны дэвсгэр зургийг үйлдэн, тухайн дурсгалуудын талаар анхны төсөөлөл бий болгохын тул тус бүр нэг булш сорилтын журмаар малтан шинжиллээ.

Хээрийн хайгуул судалгааны үр дүнг дурсгалт газар бүрээр нь доор дэлгэрэнгүй толилуулав.

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНХУТАГ СУМЫН НУТАГ СЭРВЭН ХААЛГАНЫ ОРЧИМ ЯВУУЛСАН АРХЕОЛОГИЙН ХАЙГУУЛ СУДАЛГАА

Хэнтий аймгийн Баянхутаг сумын нутаг “Сэрвэн хаалга” уул нь эртний зүрчид, хятад бичээсүүдээрээ судлаачдад танил болсон. Уг бичээсийг анх академич Х.Пэрлээ сурвалжлан олж, доктор Ц.Шагдарсүрэн, Б.Сумьяабаатар нар 1986 онд хэвлэлд нийтлүүлсэн. 1991 онд Монгол Японы “Гурван гол” төслийн профессор Ш.Като, Д.Цэвээндорж нарын удирдсан хэсэг, 2001 онд Монгол-Японы хамтарсан “Шинэ зуун” төслийн шинжилгээний анги уг бичээсүүдийг хуулбарлан авч уншин судлаад 1196 онд болсон Алтан улс Татаарыг дайлсан тулалдааны дараа сийлсэн болохыг тогтоожээ (Preliminary report ..., 2002).

Бид хээрийн судалгааны явцад Сэрвэн хаалга уулын эргэн тойрон хайгуул хийхэд гол төлөв хүрлийн үед хамаарах дөрвөлжин булш, шоргоолжин булшууд тэмдэглэгдсэн ба тэдгээрийн газар зүйн байршлыг тогтоон дэвсгэр зургийг үйлдлээ (Дэвсгэр зураг 1, Хүснэгт 1).

СҮХБААТАР АЙМГИЙН МӨНХХААН СУМЫН НУТАГТ ЯВУУЛСАН АРХЕОЛОГИЙН ХАЙГУУЛ СУДАЛГАА

Ачаат уулын палеолитийн дархны газар

N 46° 54' 08.5"	ДТД 1339 м
E 112° 14' 48.0"	Алдаа 5 м

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг, Ачаат ууланд “чулуун зэвсгийн дархны газар байх бөгөөд чулуун зэвсэг болон олон төрлийн булштай” хэмээн тэмдэглэсэн байдаг (БНМАУ-ын түүх 1966: 35). Тус хээрийн шинжилгээний анги Ачаат уулын орчим хайгуул судалгаа хийж олон арван үлдэц, залтас, ялтас цуглуулсны дотор сонирхол татахуйц гар сүх (hand axe) илрүүлсэн болно (Зураг 1).



Зураг 1. Ачаат уулаас олдсон палеолитийн олдвор - гар сүх

Устай бургастайн неолитийн бууц

N 46° 55' 08.9" ДТД 1204 м
E 112° 11' 22.7" Алдаа 5 м

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын төвөөс зүүн урагш 10 км-т орших шинэ чулуун зэвсгийн үед холбогдох энэхүү сууринг 1961 онд Д.Дорж, Н.Сэр-Оджав, нар нээн (Дорж, 1971) илрүүлснээс хойш судлаач нарын анхаарлыг татдаг сонирхолтой газрын нэг болжээ.

Хээрийн судалгааны явцад бид Устай-Бургастайн Барга элсэнд (N 46° 55' 10.4" E 112° 12' 23.3", ДТД 1204 м) хайгуул судалгаа явуулж 400-аад ширхэг зэвсэг, үлдцүүд илрүүлснээс гадна урьд өмнө олдож байгаагүй ховор сонирхолтой үзүүр мэс, зэв болон цуулж үйлдсэн чулуун хутганууд олдлоо (Зураг 2,3).



Зураг 2. Сүхбаатар аймгийн Мөнххаан сум, Устай бургастайн Барга элснээс олдсон шинэ чулуун зэвсгийн олдвор - үзүүр мэс, зэв, үлдцүүд



Зураг 3. Сүхбаатар аймгийн Мөнххаан сум, Устай бургастайн Барга элснээс олдсон үзүүр мэс ба чулуун хутганууд

**СҮХБААТАР АЙМГИЙН МӨНХХААН СУМЫН НУТАГТ ХИЙСЭН
МАЛТЛАГА СУДАЛГАА**

Замын хашаат 1-р булш

N 46° 52' 14,1" ДТД 1108.м Диаметр 3,6 м
E 112° 18' 22,3" Алдаа 5 м Хэлбэр цагираг
Чулуун дараасны өндөр 40 см

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумаас зүүн урагш 20-иод км-т Баруун-Урт орох төв замын хойд талд байх Замын хашаат (Хаалган хошуу) хэмээх уулаас баруун урагш түрсэн намхан толгойн зүүн урд хэсгээр эртний Хүрэл, Хүннү, Монголын үед холбогдох нүүдэлчдийн олон булш, оршуулга байгааг өмнөх жилүүдийн хайгуулын явцад илрүүлсэн билээ. Эндхийн дурсгал нь цагаан өнгийн хонин чулуудыг ашиглан дараас үйлдсэн, гадаад зохион байгуулалтаар харилцан адилгүй бөгөөд урьд өмнө малтан судлагдаагүй тул тэдгээрийн он цаг, соёлын хамаадал зэргийг тодорхойлохоор бид жижиг толгойн чанх урд доор, дурсгалт газрын хамгийн баруун доод хэсэгт орших булшийг сонгон малтлаа (Зураг 4, 5).



Зураг 4. Сүхбаатар аймгийн Мөнххаан сум, Замын хашаат, Були 1.
Гадаад зохион байгуулалт



Зураг 5. Сүхбаатар аймгийн Мөнххаан сум, Замын хашаат, Були 1. План зураг

Уг булш газрын хөрсөн дээрээ цөөвтөр тооны цагаан өнгийн чулуудаар үйлдсэн цагариг хэлбэрийн дараастай бөгөөд цэвэрлэгээг үйлдэн дараас чулуудыг зайлуулан малтлагыг үргэлжлүүлэхэд булшны төв хэсэгт 1,5 х 1,2 метрийн хэмжээтэй маш том чулуу байрлуулсан байв. Тэрхүү чулууг тойруулан том том хавтгай чулуудыг босгон зоож, арай бага шиг чулуудаар завсар зай үлдээлгүй чигжээд, гадна талаас нь бас жижиг чулуудаар амыг нь даран хориг хийсэн нь маш үр дүнтэй болжээ. Эртний булш оршуулгад үйлддэг хориг, хамгаалалтыг энэ булшнаас маш сайн харж болохоор байлаа. Гэсэн хэдий ч тонуулчдын гар хүрч сүйдсэн байв. Цэвэрлэгээний явцад том чулууны баруун урд

доороос ихэд муу хадгалагдан үлдсэн хүний гавал, дунд чөмөг, шилбэ, хавирганы яснууд эмх замбараагүй байдалтай илэрсэн болно.

Уг чулууны баруун талаас ногоон өнгийн хятад гаралтай шаазан савны хагархай хэсэг илэрлээ. Уг зүйл нь 5 болон 6 өнцөгтэй байсан болов уу гэмээр хятад хийцийн паалантай шаазан сав эсвэл савны таглааны хагархай бололтой байх бөгөөд өнцгийн хооронд ногоон өнгөн дээр суурилсан хар өнгийн будагтай, өнцгүүдийн дээд талд зураасан хээ бүхий товгор хүрээтэй. Энэ хүрээний доод хэсэг бор өнгийн будагтай, дээд хэсэг буюу шаазангийн орой байсан гэмээр ногоон өнгөтэй хэсэг нь эмтэрч алга болжээ. (Зураг 6) Ийм төрлийн шаазан эдлэлүүд Монголын эзэнт гүрэн болон, Юань гүрний үеийн Хятад нутгаас илэрдэг археологийн дурсгалуудад элбэг тохиолддог. Шаазан олдворын хамгийн их урт 5 см, бага урт нь 3,4 см, өргөн 2,7 см,



товгорын хүрээний зузаан 0,8 см, товгор хүрээний өргөн 0,9 см, өнцгийн зузаан 0,4 см, жирийн зузаан 0,2 см байна. Уг булшийг гадаад зохион байгуулалт, олдсон эд өлгийн зүйл дээр үндэслэн Монголын үед холбогдох оршуулга гэж үзлээ.

Зураг 6. Сүхбаатар аймгийн Мөнххаан сум, Замын хашаат, Булш 1. Шаазангийн олдвор

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг дахь эртний хотын туурь

N 46° 40' 06.3"

E 111° 50' 47.2"

ALT 1087 m



Зураг 7. Сүхбаатар аймгийн Мөнххаан сум, Тогоотын гол, Сүмийн довжоо

Сүхбаатар аймаг Мөнххаан сум, Тогоотын голд нутгийн ардууд Сүмийн довжоо хэмээн нэрлэдэг эртний нэгэн хотын туурь байдаг байна. (Зураг 7) Хойноос урагш үргэлжлэх голын хөндийд ойр орчноосоо арай өндөрлөг, байгалийн хадтай бага шиг довцог дээр барьсан уг байгууламж нь чулуун суурьтай, вааран дээвэртэй,

хөх тоосгон барилга байсан бололтой. Байгууламжийн гадуур хэрэм байсан бололтой шороон далантай, түүний хэмжээ баруунаас зүүн тийш 30 м, хойноос урагш 35 м ба нийт талбайгаараа 1.5 м орчим өндөртэй. Хэрэмний дотор 2 байгууламж байх бөгөөд баруун талынх нь арай бага, овгор, дугуйдуу хэлбэртэй, хэрэмний баруун хойд буланд шахуулан барьсан. Голдоо ухаж тоносон ул мөр бололтой нэлээн том хонхортой байв (Зураг 8).



*Зураг 8. Сүхбаатар аймгийн Мөнххаан сум, Тогоотын гол, Сүмийн довжоо
Баруун талын байгууламж*

Нөгөө байгууламжийг зүүн талд нь голлуулан барьсан. Дөрвөлжин хэлбэртэй, овгор, голдоо том хонхортой (Зураг 9).



*Зураг 9. Сүхбаатар аймгийн Мөнххаан сум, Тогоотын гол, Сүмийн довжоо
Зүүн талын байгууламж*

Уг барилгыг анх үйлдэхдээ нийт талбайгаар нь том хэмжээтэй дөрвөлжин хавтгай чулуунуудыг давхарлан өрж өндөрлөөд түүн дээрээ зөөлөн шороо, шавар асган дагтаршуулж хийсэн болох нь дөрвөлжин байгууламжийн зүүн урд өнцөгт 50 х 50 см хэмжээний талбайд хийсэн сорилтын малтлагаас харагдаж байлаа (Зураг 10).

Дөрвөлжин байгууламжийн гадна талд, хэрмийн дотор зүүн урд хэсэгт хавтгай чулуунуудыг эгнүүлэн босгож хүрээ хийсэн 1 х 1,5 м хэмжээтэй жижиг байгууламж олдов. Зүүн, урд хэсгээрээ хашлагагүй, баруун болон хойд хэсгээрээ чулуун хашлагатай, чулууны өндөр газрын хөрснөөс дээш 25 см байв. Уг

байгууламжийг малтаж үзэхэд 40 см гүнээс үнс, малын чөмөгний яс, эрүү зэрэг зүйлс илэрсэн нь тахилгын зорилгоор үйлдсэн байгууламж болохыг харуулж байна.



а.



б.

Зураг 10. Сүхбаатар аймгийн Мөнххаан сум, Тогоотын гол, Сүмийн довжгоо
а. Барилгын суурийн сорилтын малтлага, б. Тахилгын байгууламж

Энэ туурийн ойр орчмоос барилгын дээврийн ваар болон хөх туйпууны хагархай, бор өнгийн шаазан ваарын хагархай ихээр олдож байлаа. Хайгуулын явцад хэрмийн дотор том байгууламжийн орчмоос луу мэт амьтны дүрсийг товойлгон хүрлээр цутгаж хийсэн чимэглэлийн бололтой зүйлийн хэсэг, гуулин цөгцний ёроол олдлоо (Зураг 11).



Зураг 11. Сүхбаатар аймгийн Мөнххаан сум, Тогоотын гол, Сүмийн довжгооноос олдсон
хүрэл эдлэл, нүүр ваар болон ваарны хагархай

Тус байгууламж ерөнхийдөө эрт үеийн томоохон харуул, бэхлэлтийн зориулалттай хот газар байсан бололтой бөгөөд хүн оршин суусан ул мөр тодорхой харагдахгүй байлаа. Гэсэн хэдий ч ойр тойрноос нь олноор илэрч буй тоосго, дээврийн нөмрөг болон тосгуур ваар зэрэг нь тэрхүү барилгын орчимд ямар нэгэн байгууламж байсныг илтгэхээс гадна тодорхой хугацаанд хүн оршин суусан байх магадлалыг өндөрсгөж байна. Баруун хойд хэсэгт өндөр чулуун цамхаг байсан нь нуран унасан бололтой. Уг дурсгалын гэрэл зургыг Сүхбаатар аймгийн орон нутгийг судлах музейн фото цомогт багтаасан байдаг (Энхбат 2008).

Тэрхүү байгууламжаас зүүн тийш 500-аад метр-т хэлбэр хийц адилхан боловч хэмжээгээр ялимгүй том өөр нэгэн туурь байдгийг нутгийн хүмүүс хэлж байсан¹ хэдий ч цаг давчуу байсан тул очиж үзэж амжсангүй. Энэхүү дурсгалын талаар ямар

¹ Уг хэрмийг Д.Түмэн 2008 онд очиж үзсэн ба бага хэмжээний хайгуул хийж, фото зураг авсан байна. Уг байгууламжийн нэрийг Зүүн сүмийн довжгоо гэдэг ажээ.

нэгэн мэдээ сэлт, хэвлэн нийтлэгдсэн баримт байхгүй бөгөөд ямартай ч судлаачид болон нутгийн ардын аман мэдээ, фото сэлтээс үзвэл нэгэн үед холбогдох дурсгал болох нь илэрхий байна. Сүмийн довжооноос зүүн хойхно Дундад эртний үед холбогдох хаданд сийлэгдсэн Уйгуржин бичгийн дурсгал байдгийн дотор ...“хот байгуулав”... гэсэн бичээс байдаг гэх аман мэдээ байх ба зарим эрдэмтэд энэхүү хотын туурийг түүнтэй холбон тайлбар хийж, Их Монгол гүрний үед холбогдож болзошгүй хэмээн үздэг байна². Энэ удаад бид уг бичгийн дурсгалыг олж үзэж чадсангүй.

СҮХБААТАР АЙМГИЙН ТҮВШИНШИРЭЭ СУМЫН НУТАГТ ЯВУУЛСАН ХАЙГУУЛ, МАЛТЛАГА СУДАЛГАА

Сүхбаатар аймаг, Түвшинширээ сумын 4-р баг, Дэлгэрхаан багийн нутаг Тогоотын гол нь хойноос урагш чиглэн 20-иод км газар үргэлжлэх бөгөөд эрт үед баялаг устай байсан шинжтэй ба харин одоо хатаж, энд тэндээ шалбааг бүхий нойтон сайр болон хувирчээ. Тогоотын голын өмнөд шувтарга хэсгийг “Улаан зуух” гэнэ. Энэ гол урагш Зуухын хоолойгоор урсахдаа Зуухын гол болон үргэлжлэх ажээ. Нутгийнхан “Түн ус” хэмээн нийтэд нь нэрлэх энэ хавийн газар нь хойноос урагш жижиг ам болон тогтсон боржин хадтай бэсрэг толгодоос бүрдэнэ. Энэхүү газрын зэргэлдээ амнуудаар гадаад зохион байгуулалтын хувьд Монголын үеийн хэв шинжийг илтгэх булш, мөн энэ үед холбогдох хадны сүг зураг, төвд бичээс, эртний хотын туурь зэрэг олон дурсгалт зүйлс тохиолдож байлаа.



*Зураг 12. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Улаанзуух дахь
дөрвөлжин булшны цогцолбор*

Улаан зуухын баруун аманд урьд өмнө археологичид ирж, малтлага судалгаа хийж байсан тухай аман мэдээ байдаг хэдий ч аль шинжилгээний ангийн

² Д.Наваан, Х.Пэрлээ, З.Лонжид нар тэрхүү бичээсийг анх олж үзсэн гэх ба уг бичгийн дурсгалыг тус хотын туурьтай холбон тайлбарласан (Д.Навааны аман мэдээ (уг хотын туурийг өөр судлаач олж үзээгүй бололтой).

археологичид болох, ямар булш малтан судалсан талаар мэдээ баримт, өгүүлэл бидэнд олдоогүй ба тухайн судлаачийн хувийн архивт хадгалагддаг бололтой.

Энэхүү амны доод шувтаргад, хуучин голын 2 талаар олон тооны дөрвөлжин булшууд байрлах ба их төлөв голын баруун дэвсэгт оршино. Энд нэгэн доор 61 байгууламж бүртгэгдсэний дийлэнх нь гадаад зохион байгуулалтын хувьд хүрэл зэвсгийн үед холбогдох дөрвөлжин булшны гадаад зохион байгуулалттай төстэй байх ба ганц нэгэн Монгол болон шоргоолжин булш тохиолдоно (Зураг 12).



Зураг 13. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Улаанзуух дах дөрвөлжин булшны нэмэлт байгууламж

Уул бүлэг булшийг хойноос урагш цувруулан 2 эгнээгээр үйлдсэн байх ба үндсэн 3 бүлэг байж болохоор харагдаж байна. Энд байх дээрх булшууд нь гол төлөв дөрвөлжин хэлбэртэй, ихэд нягт шигүү орших бөгөөд ихэнхийнх нь төв хэсгийн булшнуудын дараас чулууд газрын хөрсөнд дарагдан харагдахгүй болсноос зарим булшнууд захаараа нийлэн нэгэн том байгууламж мэт харагдах хүндрэлтэй байлаа. Дээрх булшнуудын завсар зайд ганц нэг том хэмжээтэй шоргоолжин булш тохиолдоно. Булшийг том хавтгай чулуудыг дөрвөлжин хүрээ үүсгэн, зарим тохиолдолд давхар хүрээ үүсгэн зоож үйлдсэн ба зарим үед дараасны ерөнхий тэгээс илүү гарган нэмэлт тасалгаа маягийн дөрвөлжин хүрээ үйлдсэн булшны байгууламж ч тохиолдож байв (Зураг 13). Мөн зарим байгууламжийн 4 буланд бусад чулуунаас өндөр хөшөө чулуутай, зарим тохиолдолд зөвхөн зүүн хэсгийн хашлаганд хөшөө чулуу тавьсан тохиолдож байлаа. Ихэнх булшнууд бөөрөөрөө нийлэн байрлах агаад зарим хэсэгт 3-4 булш захаараа нийлэн оршиж байв.

Дөрвөлжин булшийг ангилах оролдлогыг анхлан 1920-иод онд Г.П.Сосновский хийсэн бөгөөд дөрвөлжин булшийг гадаад зохион байгуулалтаар 4 хэлбэрт ангилан үзжээ (Сосновский 1941). Үүнээс хойш В.В.Волков (1967), Д.Наваан (1975), А.Д.Цыбиктаров (1989), З.Батсайхан (1995), Д.Эрдэнэбаатар (2002), Ц.Төрбат (2004)

нарын зэрэг олон судлаачид удаа дараалан судалж, холбогдох он цагийг гадаад болон дотоод зохион байгуулалт, оршуулгын зан үйл, эд өлгийн хувьд сурвалжлан тогтоохыг хичээсэн ажээ. Улаан зуухад байх эдгээр дөрвөлжин булшнуудыг урьд өмнө малтан судалж байгаагүй тул дотоод зохион байгуулалт, эд өлөг, зан үйлийн хувьд харьцуулалт хийх боломж байсангүй. Зөвхөн гадаад зохион байгуулалтыг ажиглахад дээрх судлаачдын хийсэн ангиллаас өөр хэв, шинж тэмдэг харагдаж байна хэмээн үзэж байна. Эдгээр булшуудыг үйлдэхдээ намхавтар хавтгай чулуудыг дөрвөлжин хүрээ гарган зоож, төв хэсгээр хавтгай чулуудыг дэвссэн болох нь ихэнх булшны зохион байгуулалтаас сайн харагдаж байгаа ба зарим нэгэн булшны зүүн хашлаганаас үргэлжлүүлэн хавтгай чулуудыг байшингийн өрөө тасалгааг санагдуулам зохион байгуулалтаар зоосон байх бөгөөд энэ тохиолдолд нэмэлт хэсэгт ямар нэгэн чулуун дараас дэвссэн нь тохиолдохгүй байна. Энэ нь тус бүлэг булшны бусад газрын дурсгалуудаас ялгарах нэгэн онцлог шинж болж байна. Гэхдээ энэхүү тасалгаа буюу таславчтай мэт харагдаж байгаа байдал малталт судалгааны явцад өөрчлөгдөж болзошгүйг анхаарах хэрэгтэй.

Энд байрлах булшуудыг хойноос нь урагш буюу хамгийн их нягтралтай хэсгээс нь эхлэн дугаарлан, баримтжуулж, ерөнхий дэвсгэр зураг үйлдэв (Хүснэгт 2, Дэвсгэр зураг 2). Тэдгээр булшнуудаас баруун дээд толгойн орой хэсэгт байрлах нэгэн томоохон хэмжээний дөрвөлжин булш, толгойн зүүн энгэр хормойд байрлах 2 жижгэвтэр хэмжээний зууван хэлбэрийн чулуун дараастай булшийг сонгон малтав (Зураг 14, 15).

Улаан зуух 40-р булш

N 46° 39' 02.5" ДТД 1093.3
E 111° 51' 29.3" Алдаа 6м

Хэмжээ 6х7 м
Хэлбэр Дөрвөлжин




Зураг 14. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сум, Улаанзуух Булш 40. Гадаад зохион байгуулалт

Энэ нь том хэмжээний дөрвөлжин булш бөгөөд бүлэг оршуулгын баруун хойд захад жижиг боржин хадтай толгойн орой хэсэгт олон хадан цохион дунд байрлах ба

1. Бусдаас зайдуу, онцгой байдал

2. Өндөрлөг газарт ганцаар байрлаж буй явдал
3. Дээрх бүлэг булшуудад тохиолдож буй хамгийн түгээмэл хэлбэртэй байгаа зэргийг харгалзан малтахаар сонгосон болно. Ингэснээр энэхүү бүлэг дурсгалын талаар анхны мэдээллийг бий болгох боломжтой гэж үзлээ.



Зураг 15. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сум, Улаанзуух
Булш 40. Гадаад зохион байгуулалт

Уг булшийг шовх хадан цохионы зүүн доор байрлуулсан байх бөгөөд ойр орчмын газар элбэг байх боржин чулуудаар дараасыг үйлдсэн байна. Дөрвөлжин хэлбэртэй ба, өргөргийн дагуу сунан байрласан, 4 талаар нь өндөр хавтгай чулуудыг босгон зоож хашлага үйлдсэн, толгой болон хөл талын хашлага чулууд тод харагдах бөгөөд хажуу хэсгийн хашлага чулууд унасан байдалтай. Малтлагын гүн 30 см-т хүрэхэд хавтгай чулуудаар маш нягт нямбай үйлдсэн битүү чулуун шал илрэв. Түүнээс доош байгалийн хөрс илрэв. Чулуун хашлагын зүүн хойд хэсгээс малын яс илэрснээс өөр эд өлөг олдворын зүйлс илэрсэнгүй. Оршуулгын нүхний толбо хийгээд хүн оршуулсан ул мөр огт байхгүйгээс үзвэл тахилгын зориулалтаар үйлдэгдсэн байгууламж бололтой.

Улаан зуух 41-рбулш


N 46° 39' 03,9"	ДТД 1084.7	Хэмжээ	4,5х4,5 м
E 111° 51' 30,3"	Алдаа 6 м	Хэлбэр	Цагираг

Зуухын голын баруун талын хадархаг бэсрэг толгойн зүүн энгэрт зүүн урдаас баруун хойш чиглэсэн бага шиг судгийн урд талд байрлах ба том хэмжээний боржин чулуудаар гонзгой хэлбэр гарган үйлдсэн төв хэсгээрээ чулуугүй булш. Талбайлан цэвэрлэхэд хавтгай чулуудаар үйлдсэн дүгрэг хэлбэрийн дараас илрэв. Дараасны хөл

талд урт том хавтгай чулуу анхны байдлаасаа хөдөлж унасан байдалтай олдсон ба толгой хэсгээр жижиг чулуудыг бие биенийх нь амыг даруулан тавьсан байна. 88 см-ийн гүнд талбайн төв хэсэгт баруун урагш чиглэсэн жижиг хэмжээтэй (урт 70 см, өргөн 35 см) зууван хэлбэрийн толбо илэрч цааш малтахад хүүхдийн 3 ш хавирга, богтос, дунд чөмөг, ташаа зэрэг яснууд эмх замбараагүйгээр олдож түүнээс доош байгалийн хөрс тулав. Хүүхдийг оршуулахдаа баруун урд зүг толгойн орой өөд хандуулан тавьсан бололтой. Уг булш эрт үед тоногдсон бололтой бөгөөд эд өлгийн зүйл илэрсэнгүй (Зураг 16, 17).



Зураг 16. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сум, Улаанзуух
Булш 41. Гадаад зохион байгуулалт



Зураг 17. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сум, Улаанзуух
Булш 41. План зураг, Хүүхдийн оршуулга

Улаан зуух 42-р булш


N 46° 39' 04,4"	ДТД 1086.3	Хэмжээ	5x5м
E 111° 51' 29,9"	Алдаа 6 м	Хэлбэр	Дугуй



Зураг 18. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сум, Улаанзуух
Булш 42. Гадаад зохион байгуулалт

41-р булшнаас хойд зүгт 50 м-ийн зайд орших битүү чулуун дараастай дугуй хэлбэрийн булш (Зураг 18). Цэвэрлэгээний явцад дараас чулуудын баруун урд хэсгээс малын яс илэрч байлаа. Малтлагын гүн 50 см-т хүрэхэд байгалийн хөрснөөс ялгарахад маш бэрх шар, хүрэн шороо, хайрга холилдсон толбо зүүн хойноос баруун урагш чиглэлтэй илрэв. Булшны нүхний урт 210 см, өргөн 120 см. 80 см гүнээс газрын уруу буюу зүүн хойд зүг чиглүүлэн, түрүүлгээ харуулан оршуулсан эрэгтэй хүний оршуулга илрэв. Хос дунд чөмөг, шилбэ, шуу яснууд, нурууны зарим нугалам яснууд, гавал зэрэг нь анхны байрлалаа алдаагүй байх бөгөөд хөл гарын сарвуу, зарим хавирганы яснууд алга болсон байна. Цааш үргэлжлүүлэн малтахад хүний толгойн баруун хажуу болон цээжний доод хэсэгт хайрга чулуутай хүрэн байгалийн хөрс гарч байлаа. Уг булшны нас барагчаа оршуулсан тавилтын хэлбэр сонирхол татах бөгөөд ямар нэгэн байдлаар тоногдсон, анхны байрлалаас хөдөлсөн гэх шинж тэмдэг үгүй байв (Зураг 19).

Малтлагын явцад чулуугаар үйлдсэн нэг талдаа зориуд нүхлэн цоолсон онго мэт хэлбэрийн зүйл илрэв. Энэ нь байгалийн урт гонзгой хэлбэртэй хайрган чулууг дээд хэсэгт нь зориудаар нүх гарган цоолсон. Нүхийг тойрсон тойрогтой, энэ нь нэг талдаа нөгөө талаасаа бага байгаа нь чулууг эхэлж нэг талаас нь өрөмдөн нүхэлсний дараа нөгөө талаас нь дахин бага зэрэг өрөмдөж цоолсныг гэрчилж байна. Чулууны хоёр талд урт зураастай, энэ зураас нэг талдаа тод, нүхний тойргийг дайрсан, эсрэг талдаа нүхийг дайраагүй, нөгөө талыг бодвол бүдэг. Чулуу дээд хэсэгтээ буюу нүхтэй төгсгөлдөө өрөөсөн талдаа эмтэрсэн байв. Нүхтэй чулууны урт нь 12,2 см, хамгийн их өргөн нь 3,7 см, бага өргөн нь 3,6 см, хамгийн их зузаан 1,6 см, бага зузаан нь 1,4 см. Нүх нь чулууны дээд хэсгээс 1,1 см, доод хэсгээс 8,5 см, нүхний тойрог дээд хэсгээс 1,0 см, доод хэсгээс 9,3 см, нүхний диаметр 0,7 см, тойргийн диаметр 1,7 см. Нүхтэй чулуун дээрх зураас хоёр талдаа 10,4 ба 9,5см-ийн урттай (Зураг 20). Ийм төрлийн чулуун эдлэл урьд өмнө олдож байсан талаар мэдээлэл одоогоор алга бөгөөд оршуулгын зан үйлд тохиолддог өвөрмөц зан үйлийн илэрхийлэл бололтой.



а.



б.

Зураг 19. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сум, Улаанзуух. Булш 42.

а. Гадаад зохион байгуулалт, б. Хүний оршуулга

Энэхүү булш нь гадна чулуун дараасны хэлбэрийн хувьд дөрвөлжин булшны үндсэн зохион байгуулалттай адилгүй байгаа хэдий ч оршуулгын зан үйлийн хувьд дөрвөлжин булш, хүрлийн үеийн зарим соёлуудын оршуулгын зан үйлтэй адилтгаж болох тал байна.



Зураг 20. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сум, Улаанзуух.

Булш 42. Чулуун эдлэл

Хүнээ түрүүлэг нь харуулан, тэргүүнийг нь газрын уруу хандуулан тавих зан үйл булш оршуулгын зүг чигийг хатуу баримталдаг зарим нэгэн бүлэг оршуулгад

тохиолддог. Тухайлбал, хүнийг түрүүлгээ харуулан оршоосон оршуулга Өвөр Монголын нутагт малтсан дөрвөлжин булшнуудад тохиолдож байжээ (Walter 1992: 191-197).

Архангай аймгийн Батцэнгэл сумын Наймаа толгойн 13-р булшинд хүнээ түрүүлэг нь харуулан оршуулсан (Лхагвасүрэн 2007; 179), Өмнөговь аймгийн Номгон сумын Уушигт малтсан шоргоолжин булш (Өмнөговь аймгийн ..., 2008) болон Иволгийн 173-р Хүннү булшинд эмэгтэйг элгээр нь зүүн хойд зүг чиглүүлэн хэвтүүлсэн ба үүнийг Хүннүгийн булш оршуулгад тохиолдож буй маш ховор зан үйл хэмээн тэмдэглэсэн байдаг (Төрбат, 2004: 48). Дорноговь аймгийн Дэлгэрэх, Чандмань хар уулнаа малтсан 2, 3, 4, 5, 6, 9-р булшинд хүнээ түрүүлэг нь харуулан оршуулсан байжээ. Дээрхээс гадна БНХАУ-н неолитийн Ючины Цинльньчаны булшнуудад нийтлэг тохиолдож буй талаар дурьдсан байна (Амартүвшин 2007). Дээрх судлаачид археологийн баримт, угсаатны зүйн хэд хэдэн мэдээг дурьдан онцгой байдлаар нас барсан хүнийг оршуулах өвөрмөц хэлбэр байж болох санааг дэвшүүлж хүрлийн эхэн үе, Энеолитийн үед холбон үзэж болох юм гэжээ. Мөн энэхүү зан үйлийг бөө хүний оршуулгын хэлбэр (Хамзина 1970) хэмээн үзсэн байдаг. Ийм төрлийн зан үйл Монгол болон Өвөр байгаль, БНХАУ-н нутагт цөөн тоогоор тохиолддог ажээ.

Хүнээ түрүүлэг нь харуулан оршуулахаас гадна тэргүүнийг нь газрын уруу хандуулан оршуулсан оршуулга маш ховор тохиолддог. Архангай аймгийн Тамирын улаан хошуунд малтсан Хүннү булшнуудын 5-д нь нас барагчийнхаа тэргүүнийг газрын уруу харуулан оршоосон байжээ (Хатанбаатар 2008; 156-168). Монголын болон түүхийн бусад үеүдийн оршуулгын зан үйлд иймэрхүү зан үйлийн оршуулгын хэлбэр өнөө хүртэл тусгайлан судлагдаагүй бололтой. Дээрх зан үйл нь Хүннүгийн оршуулгын зан үйл дөрвөлжин булшны соёлоос шууд уламжлалтай хэмээн үздэг зарим судлаачдын үзэлд нэгэн баримт болох боломжтой юм. Учир нь Эгийн гол (Төрбат 2003) болон Тамирын улаан хошуунд малтсан хүннү булшнуудад зүүн урагш хандсан чиглэлтэй болон тэргүүнийг нь газрын уруу хандуулан оршуулсан оршуулгууд нэлээд тоогоор тэмдэглэгдсэн байдаг байна (Хатанбаатар 2008: 156-168). Энэ нь дөрвөлжин булшны соёлыг үлдээгчид болон Хүннү нарын хоорондын зүг чигийн адилслыг зарим талаар илэрхийлэх боломжтойг харуулж буй бөгөөд цаашид лавшруулан судлах шаардлагатай байна. Зөвхөн энэ төдийгүй нүүдэлчдийн оршуулгын зан үйл дэх, хүнээ зүй бусаар оршуулах зүг чиг, тавилтын талаар нэгтгэн судлах хэрэгцээг тодотгож байна.

Мөнххаан сумын Улаан зуух дахь энэхүү бүлэг оршуулга нь чулуун дараасын ерөнхий тэг, байгууламжийн хэлбэр, болон оршуулгын зан үйлийн зарим элементүүдийн хувьд бусад газрын түүхэн адил үеийн дурсгалуудаас ялгарах онцлогтой байгаа ба цаашид гүнзгийрүүлэн малтан судлах шаардлагатай чухал газрын нэг гэж үзэж байна.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутагт шинээр олдсон монгол бичээс

N 46° 39' 17,6"

ДТД 1130 м

Е 111° 48' 55,5"

Алдаа 6 м

Хээрийн судалгааны явцад манай шинжилгээний анги Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Тогоотын голын баруун талын толгодод хадан дээр бичсэн монгол бичгийн дурсгал олж илрүүлээ. Энэхүү бичээсийг урьд өмнө нь уншиж галиглан судалгааны эргэлтэнд оруулж байсан зүйлгүй бөгөөд нутгийн хүмүүсийн аман мэдээгээр уг бичээсээс гадна үүнээс их бичигтэй хад Тогоотын голд бас байдаг ажээ. Бид уг бичгийн дурсгалын гэрэл зургийг авч байршлыг тогтоон бүртгэж авлаа.

Тэдгээр бичээс нь хэд хэдэн газар боржин хадан дээр хар бэхээр бичигдсэн байх бөгөөд он цагийн уртад бэх нилээд бүдгэрсэн байв. Судлаач, доктор Ц.Баттулгын уншиж тайлснаар энэ дурсгал нь сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалд хамаарах ба сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалуудад нийтлэг тохиолдох онцлогууд ажиглагдаж байна (Зураг 21).

Өгүүлэн буй бичгийн дурсгалд тохиолдож буй бичлэгийн онцлог шинж байгааг товч тэмдэглэвэл:


1. Бичээснээ “γ”, “q” –г тодорхой ялгаж хос тэмдэгээр ялгаж тэмдэглэсэн байна
2. Бичээсийг хар бэхээр есөн мөр болгож харьцангуй гаргацтай бичжээ.
3. Үгийн дунд орсон “bü”-г тэмдэглэхдээ “ü”-гийн шилбийг тэмдэглээгүй байна.
4. Он цагийн уртад бэх нилээд бүдгэрсэн тул гэрэл зургаас уншихад багагүй бэрхшээлтэй. Тиймээс уг бичээсийг газар дээр нь үзэж судлах зайлшгүй шаардлагатай.

Бичээсийг галиглавал:

1.qai-yin
2. dur-a
3. bukü-te ulus
4. jiraqai-a
5. moyai jil qabur-un
6. terigün sar-a-yin
7. arban tabun-a
8. bičibei
9. bi qabtala kii-a yin ... болох бөгөөд шинэ үсэгт хөрвүүлвэл:

- 1.
- 2.
- 3.
- 4.
5. могой жил хаврын
6. тэргүүн сарын
7. арван тавнаа
8. бичив
9. би. болох юм.

Мөн Сүхбаатар Мөнххаан сумын 5-р багийн нутаг, Бууралхангай уулаас зүүн урагш гурав орчим км-т буй “Хавцалын адаг” хэмээх газар хар бэхээр бичсэн монгол, дөрвөлжин бичээс буй бөгөөд дөрвөлжин бичгийн тайлж уншсан эрдэмтэн Ё.Жанчив он цагийг нь XIV зуунд холбогдоно хэмээн үзсэн байна (Жанчив 2005: 144-145). Эл бичгийн дурсгалаас холгүй орших Бага бичигтийн бичээсийг бичлэгийн тиг хэлбэр, зурлага зэргийг Монгол нутгаас олдсон бусад бичгийн дурсгалтай харьцуулан үзээд он цагийн хувьд XIV –XV холбогдоно хэмээн үзэж байна.



Зураг 21. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутагт шинээр олдсон монгол бичээс

Бичээсийн он цагийн хувьд аргын болоод билгийн тооллын яг хэдий үед хамаарахыг нарийвчлан гаргах боломжгүй боловч дараа дараагийн судалгаанд бусад бичгийн дурсгалыг нь олж харьцуулан судлахад тодорхой болох бизээ.

ДОРНОД АЙМАГ, ГУРВАН-ЗАГАЛ СУМЫН НУТАГТ ЯВУУЛСАН ХАЙГУУЛ, МАЛТЛАГА СУДАЛГАА

Цагаан чулуут дах хайгуул, малтлагын үйл ажиллагаа

Дорнод аймаг, Гурван-Загал сумын нутагт сумын төвөөс зүүн урагш 10 км-т орших оройдоо хадтай 3 бэсрэг толгойг нутгийн ардууд Цагаан чулуут хэмээдэг. Энэхүү 3 толгойг тойрон хүрэл зэвсгийн үед холбогдох 162 дөрвөлжин булш байрлах бөгөөд хэмжээ, хашлага чулууны хувьд том хэмжээтэй байна. Дөрвөлжин булшнууд нь уг гурван толгойн хамгийн баруун толгойн бэл энгэрээр илүү шигүү байрлах ба эндээс эхлэн нар зөв тойрох маягаар уул дурсгалуудын газар зүйн солбицол, хэлбэр, хэмжээ онцлогийг тусган эрдэм шинжилгээний баримтжуулалтыг үйлдэв. Толгод хооронд болон орой мөн ар шил дээр ч дөрвөлжин булш байрласан бөгөөд газрын байцын хувьд боржин чулууны олдоц ихтэй байх ба гадаад байгууламжийг бүгдийг боржин чулуудаар үйлдсэн байна. Мөн цөөн тооны Монголын үед холбогдох булш тааралдах бөгөөд өвсны гарц сайтай жил байсан учир зарим бага хэмжээний

дөрвөлжин болон Монголын үед холбогдох дурсгалууд бүртгэгдээгүй үлдсэн байж болохыг үгүйсгэхгүй. Энд Д.Наваан 1967 онд 10 булш малтан судалсан ба зарим үр дүнгийн талаар нэгэн сэдэвт зохиолдоо тусгасан байдаг (Наваан 1975). Үүнээс гадна Гурван загалын дөрвөлжин булшнууд хэмээх нэртэйгээр “Монгол нутаг дахь түүх соёлын дурсгалт зүйлс” хэмээх сэдэвчилсэн лавлахад багтан оржээ (Энхбат 2008).


Цагаан чулуут, Булш 1

N 49° 05' 23.4"	ДТД 928 м	Хэмжээ	320 x 450 см
E 115° 02' 46.4"	Алдаа 5 м	Хэлбэр	Цагираг

Энэхүү булш нь Цагаан чулуутын хамгийн зүүн захад орших толгойн баруун урд энгэрт байрлах ба баруун урдаас зүүн хойш чиглэсэн, боржин чулуугаар үйлдсэн цагираг хэлбэрийн булш (Зураг 22, 23). Малтлагын нүх 60 см болоход зүүн хойш чиглэсэн оршуулга илрэв. Хүнээ байгалын хад ухан оршуулсан байлаа. Хүний ясны хадгалалт маш муу байсан боловч ахимаг насны эрэгтэй хүнийг толгойг зүүн хойш чиглүүлэн тэнэгэр байдлаар дээш харуулсан оршуулсан болохыг олдсон яснуудаар тодорхойлох боломжтой байв. Хүний цээжин хэсгийн яс нэлээн эмх замбараагүй байдалтай, гарын зарим яснууд анхны байрлалаасаа нэлээд хөдөлсөн, сарвууны яснууд аарцагны доор бөөгнөрсөн, харин хөлийн яснууд анатомийн байрлалаа хадгалан үлджээ.



*Зураг 22. Дорнод аймаг, Гурван-Загал сум, Цагаан чулуут, Булш 126.
Гадаад зохион байгуулалт*



Зураг 23. Дорнод аймаг, Гурван-Загал сум, Цагаан толгой, Були 126. План зураг, оршуулга

1. Төмөр зэв
2. 6 ширхэг төмөр болон 1 ширхэг ясан зэв
3. Төмөр амгай
4. Бог малын дал, дунд чөмөгний яс


Гарын урт яснууд, сарвууны яснуудын байрлалыг харахад зүүн гарыг зөрүүлэн тавьсан байж магадгүй байлаа. Нас барагчийн зүүн тавхайн гадна талд бог малын дал болон

дунд чөмөгний ясыг тахилгын идээ шүүс болгон дагалдуулсан байна (Зураг 24).




Зураг 24. Дорнод аймаг, Гурван-Загал сум, Цагаан чулуут, Були 126. Оршуулга, эд өлгө

1. Төмөр зэв
2. 6 ширхэг төмөр болон 1 ширхэг ясан зэв
3. Төмөр амгай
4. Бог малын дал, дунд чөмөгний яс



Зураг 25. Дорнод аймаг, Гурван Загал сум, Цагаан чулуут, Були 126. Ясан ба төмөр зэвүүд:

1. Ясан харвуул зэв,
- 2,3. Нарийн харвуул зэв,
- 4,5,6,7 Хануур зэв,
8. Харвуул зэвний сурвалж. (Батсайхан, Мэнэс, 1995)



Зураг 26. Дорнод аймаг, Гурван-Загал сум, Цагаан чулуут, Булш 126. Амгай

